

БАТЛАВ
МОГОД СУМЫН ЗАСАГ ДАРГА  Б.МӨНХБААТАР

**ХУЛЖИЙН ХАЛУУН РАШААНЫ ОРЧИМ ОТОГЛОХ ЦЭГИЙН ХАШАА
БОЛОН ТОХИЖИЛТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Дугаар 01



2024.03.18

1.	Зураг төсөл зохиох үндэслэл	Сумын ИТХ-ын Хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн IX/05 тоот тогтоолын 2 дугаар хавсралтын 2.1 ажлын хөрөнгө шийдэгдсэн болно.
2.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Орон нутгийн төсөв /ОНХСан/
3.	Инженерийн байгууламжийн бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none">- Отоглох цэгийн хашааны урт 450 м газар- Сурталчилгааны самбар 1ш- Авто зогсоол 2ш- Зогсоолын тэмдэглэгээ 2ш- Сүүдрэвч 2 ширхэг /4м*4м харьцаатай/- Хогийн сав 2ш /зөөврийн/- MNS 592:2015 Стандартын бие засах байгууламж 1 ширхэг /хогийн савтайгаа хамт/- Гэрэлтүүлэг 4 ширхэг- Хаалга 2ш- Явган хүний зам- Отоглон амрагчдын амрах талбайг тусгаарлах- Задгай гал түлэх цементэн талбай 1ш- Гар угаах, угаалтуурын хэсэг
4.	Отоглох цэгийн хашаа болон тохижилтонд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none">- Байгалийн хүчин зүйлүүдийг тооцоолж түүнээс хамгаалах шаардлагад нийцүүлэх- Хашааны өндөр 1,2м, шон хоорондын зай 3 м , газрын гүнд 30 см суулгасан байна. Шонгоос шонгийн хооронд 2 эгнээ трос татна, 100 м тутамд чангалагч байна.- Хашааны шонг 7,5*7,5 см дөрвөлжин модон шонгоор хийж, шон тус бүрийг нүхлэж трос татаж, газарт суулгасан хэсгийг бетоноор цутгаж бэхэлнэ.- Хашааны хаалга 2ш/хашааны ард, урд/. 80см өргөнтэй 1,2м өндөртэй, угольник төмрөөр рам гагнаж торон хаалга хийх /чимэглэлтэй/. Хаалганы 2 талын тулгуур шон баганыг газарт суурилуулж цементээр бэхлэх.- Сурталчилгааны самбарыг 2х1,20 мм-ийн угольник төмрөөр рам хийж лист 8мм-ийн гагнаж болно.- Гадна орчны үйлчлэлийг 4-өөс доошгүй жил тэсвэрлэх материалаар гүйцэтгэх.- Металл хийцийг гагнуураар чанартай холбосон байх ба зэврэлтээс хамгаалах будгаар 2 давхар будсан байх<ul style="list-style-type: none">- Авто зогсоол /урд хаалганы 2 талд зогсоолын тэмдэглэгээ хийх, авто машин эгнээгээр байрших, парклах зогсоолын заагийг 1 машин орох хэмжээтэйгээр 3 м тутамд цагаан тоосгыг газарт хагас ухаж суулгаж хаших

		<ul style="list-style-type: none"> - 4*4м харьцаатай сүүдрэвч 4 ширхэг /2 м урттай модон сандал, тавцангийн өргөн 20 см, тавцанг 5 см зузаантай банзаар хийж хөл тулгуурыг 7,5*7,5см харьцаатай палкаар хийнэ/ - Хогийн сав 2ш /зөөврийн, 80см өндөртэй, 60 см өргөнтэй төмөр сав. Эх биеийг тор төмрөөр, доод ёроолыг лист төмрөөр гагнаж хийнэ/ - Хогийн сав 1ш /овор хэмжээтэй хог хийх боломжтой 1,5*1,5м хэмжээтэй. MNS 592:2015 стандартаар хийх. Хог ачих машинд зориулагдахаар/ - MNS 592:2015 Стандартын бие засах байгууламж 1 ширхэг /тайлбайн зүүн урд буланд хийнэ/ - Гэрэлтүүлэг 4 ширхэг 4м өндөр /явган хүний зам дагуу хийх гэрэлтүүлэг, нарны эх үүсвэрээр ажиллана/ - Явган хүний зам /96 м урттай, 2 м өргөн явган хүний замыг 10 см зузаантай дайргаар дүүргэнэ/ - Отоглон амрагчдын амрах талбайг эмх цэгцтэй байлгах үүднээс 10м тутам газрыг нэг шугаманд байрлуулж, цагаан тоосгыг газарт хагас ухаж суулгаж хаших /явган хүний замын 2 талаар харалдаа 5 эгнээ сүүдрэвч хүртэлх зайд/ - Задгай гал түлэх талбайг 4*4м газрыг 2см зузаантайгаар цементлэх /гол хэсгийг ухаж гал түлэх зориулалтаар хонхор болгож цементлэх, хонхор нь 20см өргөнтэй, 10см гүн байх/ - Гар угаах гоожуурын өндөр 1,2м өргөн нь 1м, цорго 2ш, угуултуурын ус тоссон хуванцар цооног байх ба тоссон усыг 10см өргөнтэй хуванцар хоолойгоор газар доогуур явуулах, хуванцар хоолойг 20см ухаж суурилуулах, бохир ус руу 2м зайнаас дамжуулах
5.	Захиалагч байгууллага	Булган аймгийн Могод сумын Засаг даргын тамгын газар
6.	Онцгой нөхцөл	- Үерийн усны эрсдэлийг тооцох
7.	Төсөвт өртөг	50,000,000 төгрөг